




PRIORITY PASS DIGITAL ГЭЖ ЮУ ВЭ?

Голомт банкны ВИП зэрэглэлийн картууд болох Премьер дебит, Платинум кредит болон Ворлд кредит карт эзэмшигчдэд зориулсан нисэх онгоцны буудлынлоунжид үйлчлүүлэх үйлчилгээ юм. Нэмэлт бүртгэлгүйгээр шууд төлбөрийн картаар эсвэл Priority Pass аппликэйшнаар дамжуулан карт тус бүрийн нөхцөлийн дагуу лоунж руу нэвтрэх боломжтой.

Дэлхийн 600+ хотын 1500+ онгоцны буудлын лоунжид нэвтрэх

Онгоцны буудлаас тосох үйлчилгээ

Олон улсад машин түрээслэх үйлчилгээ

Премьер дебит

Карт эзэмшигч = 35\$

Платинум кредит

Зочин = 35\$

Ворлд кредит

Карт эзэмшигч +1 Зочин = Үнэ төлбөргүй

ТӨЛБӨРИЙН КАРТААР НЭВТРЭХ



Харилцагч нэмэлт бүртгэлгүйгээр төлбөрийн карттайгаа лоунж дээр очно.

Харилцагч төлбөрийн картаа онгоцны тасалбарын хамт лоунжийн ажилтанд өгч "Priority Pass" гэж хэлнэ.

Ажилтан төлбөрийн картыг лоунжийн тусгай төхөөрөмж дээр уншуулна. BIN-г бүртгэлтэй эсэхийг шалгана.

Ажлын 3-5 хоногийн дотор Приорити Пасс систем нь автоматаар карт эзэмшигчээс лоунжийн төлбөрийг татна.
[Ворлд картын хувьд карт эзэмшигч болон 1 зочин үнэгүй болон нэмэлт зочны төлбөрийг Ворлд картаас татна.]

Харилцагч тусгай төхөөрөмж дээр лоунжаар нэвтрэхээ баталгаажуулан гарын үсэг зурсанаар лоунжаар үйлчлүүлнэ.

АППЛИКЭЙШНААР ДИЖИТАЛ КАРТ ҮҮСГЭХ ЗААВАР

Priority Pass аппликэйшнийг татаж "Activate your account" товчийг дарна.

"Payment Card Number" буюу төлбөрийн картаар идэвхжүүлэхийг сонгоно.

Овог, Нэр, Имэйл хаягийг оруулна.

Төлбөрийн картын мэдээллүүдээ оруулна.

Бүртгүүлсэн имэйл/ утасны дугаараа OTP кодоор баталгаажуулан "Confirm" товчийг дарна.

Бүртгэл амжилттай болсноор имэйлээрээ "Login" хийж нэвтрэнэ.

АППЛИКЭЙШНААР ДИЖИТАЛ КАРТ ҮҮСГЭХ ЗААВАР

"Explore" цэсээс орох лоунжийг сонгоно.

Лоунжийн дэлгэрэнгүй мэдээлэлтэй танилцан "View your card" товчийг дарна.

Нэвтрэх QR код гарч ирэх бөгөөд лоунжийн ажилтанд үзүүлэн нэвтрэнэ.

Нэвтрэх эрхийг Apple Wallet-д нэмж болно.

FAQ

1. Priority Pass дижитал гэж юу вэ, өмнөх хар пластик PP картаас ямар ялгаатай вэ?

Priority Pass дижитал бол Голомт банкны Виза брэндийн Премьер дебит, Платинум кредит болон Мастеркарт брэндийн Ворлд кредит картад дагалдаж байгаа шинэчлэгдсэн онгоцны буудлын лоунжаар үйлчлүүлэх үйлчилгээ юм.
Давуу тал:

- Нэмэлт пластик/бүртгэлгүйгээр шууд төлбөрийн картаар лоунж руу орох боломж
- Хуучин хар пластик PP биедээ авч явах шаардлагагүй, нэмэлт пластик картаас хамааралгүй байгаль орчинд ээлтэй
- Priority Pass аппликэйшнаар бүртгэл үүсгэн Дижитал гишүүнчлэлийн картаар лоунж руу орох боломж

2. Би картаа алдсан тохиолдолд PP эрх нь хүчинтэй хэвээрээ байх уу?

Картаа алдсан тохиолдолд та Голомт банканд хандаж картаа блоклох хэрэгтэй. Мөн PP аппликэйшнаар алдсан картаа хасаж "Remove" дарж эрсдэлээс сэргийлээрэй.

3. PP лоунжийн эрхийн хугацаа хэдэн хүртэл вэ?

Таны PP үйлчилгээг авах эрхтэй төлбөрийн картын хугацаатай ижил байна

4. Манай гэр бүлийн гишүүн, найз нөхөд надгүйгээр миний PP эрхийг ашиглах боломжтой юу?

Боломжгүй, энэ нь зөвхөн карт эзэмшигчид зориулсан тусгай үйлчилгээ юм. Харин та өөрийн биеэр хамааралтай хүмүүстэй хамт аялаж байгаа бол лоунжид орохдоо зочин байдлаар дагуулж орж болно. (Лоунжийн ажилтан boarding pass, паспорт дээрх овог нэрийг төлбөрийн карт/дижитал PP карт дээрх овог нэртэй тулган харж шалгадаг.)

5. Би өөрөө төлөх лоунжийн төлбөр яагаад шууд картнаас татагдахгүй байна вэ?

Лоунж нь худалдааны байгууллага биш бөгөөд лоунжуудыг нэгтгэн зохицуулдаг Priority Pass компанид харьяалагддаг. Тиймээс тухайн лоунж нь нэвтрэх үед төлбөрийг шууд авахгүй, битүүмж үүсгэнэ. Priority Pass нь зочилсон өдрөөс хойш 3-5 хоногийн дараа төлбөрийг картнаас тань татах юм.

6. Лоунжийн төлбөр, тав тух гэх мэт асуудал гарсан тохиолдолд хаана холбогдох вэ?

Дараах сувгуудаар Голомт банканд хандана уу. Бид таны гомдол/санал хүсэлтийг Priority Pass руу илгээж, асуудлыг шийдвэрлэхэд туслах юм.

- Лавлах төв: 1800 1646
- VIP лавлах: 7000 1646
- Viber дугаар: 9944 1646